# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
# БАЯНХОНГОР АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 23 Номгон

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | | |
| 1 | 1 | Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ | 1.12/. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах. | Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр Бүжгийн ордон болон Хөнгөн атлетикийн барилгын талбайн газрын асуудлыг ИТХ-аар оруулан шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Салбарын 2025 оны төсөв 3,829,024.0 төгрөг болж 2024 оны төсвөөс 21.1 хувь буюу 667,698.000 төгрөгөөр нэмэгдүүлж батлуулан ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |
| 2 | 2 | Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг | "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд сургалт нөлөөллийн ажлыг 3 удаа зохион байгуулж нийт ажилтан алба хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах; | | | | |
| | 3 | | 1.3 . төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах. | Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд 5 ажил арга хэмжээг төлөвлөн батлуулж хэрэгжүүлсэн. Байгууллагын дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-нд 2025 онд нийт 6 өргөдөл шийдвэрлэж холбогдох хариу болон дүгнэлтийг газрын даргад хүргүүлсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд ажилтан, албан хаагчдад нийтлэг хэм хэмжээ зарчим, ёс зүйн асуудал эрхлэх эрх бүхий байгууллага, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гомдол, мэдээлэл хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэх, ёс зүйн зөрчил, мэдээллийн цахим сан сэдвүүдээр албан хаагчдад сургалтыг зохион байгуулж ажилтан, албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлсэн. | Хэрэгжсэн - 100% | | |
| 3 | 4 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ | 1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангах үр дүнд хяналт тавьж ажиллах; | """"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх сургалт нөлөөллийн ажил АХА тэмцээн, ХҮНДЭЛЬЕ, ЭНЭРЬЕ" УРИАТАЙ ёс зүйн нөлөөллийн сарын аяныг хүрээнд төлөвлөгөө боловсруулан батлуулж сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. " | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | | 1.1.3. 3/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10.3 дахь заалт Ёс зүйн дэд хороо нь бие даасан, хараат бус зарчмаар ажиллаж байна. Төрийн алба хаагчийн ёс зүйн зөрчлийн бүртгэл мэдээллийн программын бүртгэл мэдээллийг тухай бүр оруулан хэвийн ажиллуулж байна. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 6 | | 1.3.1. 1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.4.1 дэх заалт 13.4.1 дэх заалт ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах энэ хэрэгжилт муу тул цаашид урамшууллыг хуулийн хүрээнд олгохыг анхраан ажиллана. 2025 онд 1 удаа 1 сарын урамшууллалыг олгосон. | Хэрэгжсэн - 100% | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 4 | 7 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 | 1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах; | Баянхонгор аймгийн Усан бассейн бүхий спорт цогцолбор нь 2025 онд иргэд, хүүхэд залуучуудыг биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын олон төрлийг хөгжүүлэх зорилгоор 2025 оны 1 дүгээр сараас 12 дугаар сарын байдлаар нийт 105 спортын арга хэмжээ (уралдаан, тэмцээн, сургалт, өдөрлөг зэрэг) зохион байгуулж, нийт 54,345 тамирчин, иргэнийг хамруулсан байна.Усан бассейн бүхий спорт цогцолборт нийт 10 төрлийн секц, дугуйлан тогтмол үйл ажиллагаа явуулж, 5–18 насны 340 хүүхэд спортын сургалт, бэлтгэлд хамрагдаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 8 | Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2025-04-03 Дугаар 2025_44 | 1.. Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай.<br>2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай. | Байгууллагын хуваарьт талбайд 54 ширхэг Улиас мод тарьсан.Үүнээс ургаж чадаагүй 6 ширхэг Улиас модыг нөхөн тарьж ажиллалаа. | Хэрэгжсэн - 100% | | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| 6 | 9 | Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-11-27 Дугаар 2024_191_01 | 2.3.. Аялал жуулчлалын нэгдсэн цаглабрыг боловсруулж, улирлын онцлогийг харгалзан салбарын олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын зарим арга хэмжээг жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт. | 2025 оны 10 дугаар сарын 01-нээс 2026 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах-5, Насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах-8, Ахмадын аймгийн аварга шалгаруулах-2, Спортын наадам -2 удаагийн нийт 17 удаагийн тэмцээнийг тус тус зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар нь дараах нийт 19 удаагийн уралдаан, тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | 10 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-07-23 Дугаар 2025_29 | 1.6. хүүхэд, залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн соёл, спорт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд тайлбарлан ойлгуулах ажлыг тогтмол зохион байгуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар нь хүүхэд, залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэднийг биеийн тамир, спорт, урлаг, соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зорилгоор спортын 15-20 уралдаан тэмцээн, 10 төрлийн секц, дугуйланд 340 хүүхдийг хамруулан үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан. Хүүхэд, залуучуудын бие бялдар, сэтгэл зүйн хөгжилд чиглэсэн сургалт, лекц, уулзалт, ярилцлагыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар хүүхэд, залуучуудад ойлгуулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, зөвлөгөө, гарын авлага, мэдээллийн өдөрлөг зохион байгуулж, өсвөр үеийн тамирчдад хүргүүлэн ажиллаа. | Хэрэгжсэн - 100% | | |
| Ерөнхий сайдын захирамж | | | | | | | |
| 8 | 11 | Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-08-13 Дугаар 2025_64 | 5.. Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай. | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай 2 удаагийн суралтыг зохион байгуулж ажилласан ба эхний сургалтад Байгууллагын 25 албан хаагч, дараагийн сургалтад 13 албан хаагч тус тус сургалтад хамрагдсан. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх,чиглэлээр шинээр санаачилга гарган Бүх албан хаагчдыг Авлигаас ангид байхыг уриалж, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх гарын үсгийн БАТАЛГАА авч гарын үсэг зуруулж ажиллалаа. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 9 | 12 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39 | 39.29.11.1.7. Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил гаргахгүй байх, гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах | Тайлант хугацаанд Захиргааны ерөнхий хуультай холбоотой зөрчил гараагүй байна. | Хэрэгжсэн - 100% | | |
| 10 | 13 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-02 Дугаар 2025_15 | 10.4.1.. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг доор дурдсан албан тушаалтнуудад даалгав: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Байгууллагын ил тод, нээлттэй мэдээллийг байгууллагтай хамаарал бүхий үзүүлэлтүүдийн дагуу 3, 4-р улиралд байршуулсан.Биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн сан болох cpanel.sport.gov.mn сайтад Монголын хүүхдийн зуны спортын VIII наадамд оролцох баг тамирчдын бүртгэлийг хийж баталгаажуулсан.Аймгийн хэмжээний спортын наадам, арга хэмжээний талаарх тоон мэдээллүүдийг 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/646 тоот тушаалаар батлагдсан Спортын наадам, арга хэмжээний талаарх тоон мэдээллүүдийг 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/646 тоот тушаалаар батлагдсан BTS маягтын дагуу цуглуулан тухай бүр баяжилт хийн ажиллалаа. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 14 | | 10.4.4.. Эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, Засгийн газрын агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн | Хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд зөрчил гаргалгүй ажиллалаа. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16 | хуулийн этгээд буюу мэдээлэл хариуцагчдын хууль биелүүлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| | 15 | | 28.1.3.. иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | Байгууллага нь жилийн эцсийн байдлаар 70 өргөдөл гомдол ирсэнийг дугаар өгөн бүртгэлийн дардас дарж бүртгэлийн дэвтэрт бүртгэлжүүлсэн өргөдөлийг агуулгаар нь ангилж үзвэл ажилд орхыг хүссэн-6, дотоод журмын дагуу чөлөө хүссэн-50, ажлаас гарахыг хүссэн-3, хүсэлт-8 , ээлжийн амралт хүссэн-3, нийт 70 өргөдөл гомдолыг хүлээн авч холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд шийдвэрлэж өргөдөл гомдлын мэдээг хагас бүтэн жилээр төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн Хүлээн авсан өргөдөл гомдлыг /eoffice.bayanhongor.gov.mn/ программд бүртгэн шивж скайнардан оруулан ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 16 | | 28.2.1.. 1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгав: 1.1.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын | Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг цаглаварт хугацаанд тухай бүр тогтмол гаргаж холбогдох газарт https://bayankhongor.igovernment.mn/ цахим санд мэдээллийг оруулж тайлаганан ажиллалаа. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарах;<br>1.2.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв тайлагнах;<br>1.3.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зохицуулалтад шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх; 1.4.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг тогтмол хянаж, үр дүнг нэмэгдүүлж ажиллах. | | | | |
| | 17 | | 28.14.1.3.. шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж ажиллаагүй байгууллага, албан тушаалтанд | Тайлант хугацаанд нийт 154 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг хугацаанд нэмэлт шаардлагтай мэдээллийг бүрдүүлэн засварлан байршуулан ажилласан байна. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн | хууль, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцож ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт. | | | | |
| | 18 | | 16.4.3.. 2.төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх; | Байгууллагын цахим сайт болох baynkhongor.sport.mn цахим сайт болон байгууллагын цахим сан cpanal6sport.gov.mn, soril.sport.mn сайтуудыг бүртгүүлэхээр хүсэлтээ өгсөн. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 19 | | 16.4.3.. 3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх. | Байгууллагад Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх үйлчилгээ байхгүй | Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй | | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | |
| 13 | 20 | ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ | 1.13. 1.13. Аймаг, нийслэлийн хэмжээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг хэвшүүлэх, биеийн тамирын дасгал сургуулилтаар хичээллэх боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх; | Аймгийн хэмжээнд 56 спорт заал үйл ажиллагаа явуулж Биеийн тамир, спортын 105 арга хэмжээ зохион байгуулсан.Нийт 54,338 иргэд хамрагдсан. -Төрийн 48 байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж нийт 46,080 албан хаагч Биеийн тамир, спортын үйлчилгээ аваад байна. -Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг бага нас, өсвөр үе, насанд хүрэгчид, Ахмад гэсэн 4 насны ангиллаар нийт 24 арга хэмжээнд 3100 тамирчид хамрагдлаа. -Нийтийн биеийн тамирын 12 арга хэмжээ зохион байгуулж 5,217 иргэн хамрагдав. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2025-03-07 Дугаар 2025_03 | | | | | |
| 14 | 21 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 | 1.2.. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах; | Байгууллага Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 22 | | 1.5.. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах; | Байгууллага нийт 36 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаагаас Төрийн захиргааны 6, Төрийн үйлчилгээний 30 ажилтан албан хаагч ажиллаж байна. Төрөөс спортын талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ аймгийнхаа иргэдэд нээлттэйгээр спортын үйлчилгээг /секц, дугуйлан/ мэргэжлийн чадварлаг багш дасгалжуулагчаар удирдуулан хүртээмжтэй, хүргэн ажиллаж байна. Спортын 8 төрлөөр 258 хүүхэд хичээллэж байна. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 23 | | 2.2.. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Тайлант хугацаанд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй нийтэд ил болгох мэдээлэл гараагүй. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 24 | | 2.3.. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага хуулийн этгээдийн хэмжээнд, | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн дагуу холбогдох мэдээллийг цахим сүлжээгээр нийтэд мэдээлэн ажилласан.Одоогоор зөрчсөн албан хаагч байхгүй. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох; | | | | |
| | 25 | | 2.4.. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх; | Авлигаас ангид байх,Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээ, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх "АХА" тэмцээн, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээ, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх "АХА" тэмцээн, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 5 постер мэдээллийг бэлтгэн албаны пэйж хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэл түгээн ажилласан. ХҮНДЭЛЬЕ, ЭНЭРЬЕ" УРИАТАЙ ёс зүйн нөлөөллийн сарын аяныг хүрээнд төлөвлөгөө боловсруулан батлуулж сургалт нөлөөллийн ажлыг зохион | Хэрэгжсэн - 100% | | |
| | 26 | | 2.5.. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх; | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахын зэрэгцээ албан хаагчдад аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх,Төрийн албан албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 27 | | 2.6.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал гаргаагүй, хэрэгцээгүй худалдан авалт, хийгдээгүй төсвийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах. | | | | |
| 15 | 28 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар 2025-07-08 Дугаар 2025_03 | 1.1. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх | Байгууллагын үйл ажиллагаа болон цаг үеийн зохион байгуулалтын арга хэмжээг нийтэд цахим сүлжээгээр түгээж, тэмцээн уралдаанд оролцогчдыг цахимаар бүртгэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 29 | | 1.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээний тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 30 | | 1.5. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх | Өдөр тутмын үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль,Хөдөлмөрийн хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль,Төрийн хаагчийн ёс хэм хэмжээний хэрэгжилтийг удирдлага болгон | Хэрэгжсэн - 100% | | |
| | 31 | | 1.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал гаргаагүй, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хийгдээгүй, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулаагүй. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 32 | | 2.1. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал гаргаагүй, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хийгдээгүй, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулаагүй. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 33 | | 2.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг байнга ил тод, нээлттэйгээр иргэдэд хүргэн ажиллаж байна. Энэхүү ажиллагаатай холбогдуулан зөрчил гаргасан албан хаагч байхгүй. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 34 | | 2.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж үйл ажиллагааг нь идэвхжүүлэх | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог байгуулж ирсэн өргөдөл гомдол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 35 | ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04 | 1.2.. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад; | Байгууллагын орон тоог нэмэгдүүлэх, байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдөх ажилтан, албан хаагч байхгүй.Албан тушаалтны орон тоо болон сул орон тоо байхгүй, нөхөн томилгоо хийгээгүй. | Хэрэгжсэн - 100% | | |
| | 36 | | 1.3.. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад; | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд ажилтан, албан хаагчдад нийтлэг хэм хэмжээ зарчим, ёс зүйн асуудал эрхлэх эрх бүхий байгууллага, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гомдол, мэдээлэл хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэх, ёс зүйн зөрчил, мэдээллийн цахим сан сэдвүүдээр "Ёс зүйн дэд хороон"-оос сургалтыг зохион байгуулж хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэн ажиллаж байна. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 37 | | 1.7.. Төрийн албаны тухай хуульд заснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт; | Төрийн албаны тухай хуульд заснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөх, халах, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах, төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргаагүй. | Хэрэгжсэн - 100% | | |
| 17 | 38 | ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04 | 1.8.. ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим | Ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх ажиллагаа хийгдээгүй. | Хэрэгжсэн - 100% | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт | | | | |

ХЯНАСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ХҮРЭЛЧУЛУУН

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН Э.ДОЛЖИНСҮРЭН